

ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН  
ДАРГА

БАТЛАВ

С.ТӨМӨРДУЛАМ

2023 оны ᠒8 дугаар сарын ᠒8



## ХОТЫН СТАНДАРТЫН МОБАЙЛ АППЛИКЕЙШНЫ СИСТЕМИЙН ШИНЖИЛГЭЭ БА ДИЗАЙН ГАРГАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2023 оны ᠒8 дугаар сарын ᠒8

Улаанбаатар хот

### ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Баримт бичгийн нэр:	Хотын стандартын мобайл аппликейшны системийн шинжилгээ ба дизайн гаргах
Ажил гүйцэтгэх хугацаа:	Гэрээ байгуулагдсан өдрөөс хойш 45 хоног

### ҮНДЭСЛЭЛ:

Хотын стандартын мобайл аппликейшны системийн шинжилгээ ба дизайн гаргах ажил нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцэх бөгөөд дараах баримт бичгүүдэд тусгасан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний бүрэлдэхүүн хэсэг болно. Үүнд:

- "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;
- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр;
- Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 31.3, 32.2.3;
- Хот байгуулалтын тухай хуулийн 22.1.1;
- Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10<sup>1</sup> дүгээр зүйлийн 10<sup>1</sup>.1.

### ЗОРИЛГО:

Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах чиг үүргийн хүрээнд хотын стандартын аппликейшн хөгжүүлэх.

### ЗОРИЛТ:

Хотын стандартыг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах, мэдээллийн ил тод байдлыг хангах, мэдээ мэдээллийг түргэн шуурхай түгээх, бүтээн байгуулалтын ажил гүйцэтгэгчдийн хүний нөөцийн чадавхыг сайжруулах, мэргэшүүлэх зорилт

бүхий аппликейшны системийн шинжилгээ ба дизайн гаргахад энэхүү ажлын даалгаврын зорилт оршино.

### ГҮЙЦЭТГЭЛИЙН ШААРДЛАГА:

Мобайл аппликейшны системийн шинжилгээ ба дизайн гаргах ажлыг дараах чиглэлийн дагуу зохион байгуулна. Үүнд:

1. Мобайл аппликейшн хийлгэж байгаа зорилго, тулгарч байгаа асуудал, зорилтот зах зээл зэргийг захиалагчтай сайтар ярилцан, вэб сайтын болон түүнд тавигдах техникийн шаардлагыг тодорхойлох.
2. Аппликейшны UI (user interface) нь байгууллагын вэбсайтын загвартай зохицсон байх.
3. Аппликейшн хөгжүүлэх хамгийн зохистой технологи, аргачлал, бүтэц, дизайны нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулан захиалагчид хүргүүлэх.
4. Аппликейшны дизайн, архитектур, агуулга удирдах систем /CMS/, өгөгдлийн сангийн бүтэц зохион байгуулалтыг гаргах.
5. Аппликейшний дизайныг хэрэглэгчид хамгийн ойлгомжтой ашиглахад хялбар байхаар төлөвлөж хуудас тус бүрээр зөвхөн тухайн захиалагчид зориулсан дизайн гарган захиалагчаар батлуулах.
6. Аппликейшн нь дараах цэсийг агуулна. Үүнд:

№	Үндсэн цэс	Хөгжүүлэх хуудас
1	Хотын стандартууд	- Хотын стандарт - Цахим сэтгүүл
2	Видео суваг	- Хотын стандартын танилцуулга
3	Хичээл	- Хотын стандартын хичээлүүд - Тест
4	Санал	- Санал авч буй стандартын төсөл - Сэтгэл ханамжийн судалгаа - Санал хүсэлт

### ЗӨВЛӨХӨД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэгч нь дараах шаардлагыг хангасан 3-аас доошгүй гишүүнтэй хуулийн этгээд байна. Үүнд:

*Мэргэжил:*

- *Багийн ахлагч:* UI & UX дизайнер байх.
- *Багийн гишүүд:* Мэдээллийн технологийн мэргэжилтэн, Программ хангамжийн архитектур, Системийн программист, График дизайнер мэргэжлээр бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй, мэргэшсэн байх.

*Туршлага:*

- Багийн ахлагч: Мобайл аппликейшн хөгжүүлэлтийн чиглэлээр томоохон төслүүд дээр ажиллаж байсан туршлагатай байх.
- Багийн гишүүд: Мэргэжлээрээ 1-ээс доошгүй жил ажилласан байх.

- Гар утасны аппликэйшны систем, загвар боловсруулж байсан ажлын туршлагатай байх.
- Тухайн сэдвийн хүрээнд гадаад улс, олон улсын туршлагыг судлах зохих шатны мэдлэгтэй байх.

### АЖИЛ ТАЙЛАГНАХ ҮЕ ШАТНЫ ХУВААРЬ:

Судалгааны ажил нь дараах үе шаттай байна. Үүнд:

Д/д	Ажлын үе шат	Хугацаа 45 хоног	Тавигдах шаардлага
1	Суурь судалгаа хийх	14	1. Судалгааны хүрээнд хийгдэх ажлуудын мэдээллийг цуглуулж аргачлалыг боловсруулсан байна 2. Захиалагчаас санал авах 3. Саналыг тусган сайжруулан засварлах
2	Дундын тайлан боловсруулах	28	1. Дундын тайлан боловсруулах 2. Захиалагчаас санал авах 3. Саналыг тусган сайжруулан засварлах
3	Тайланг эцэслэн хүлээлгэн өгөх	45	Судалгааны тайланг эцэслэн хүлээлгэн өгөх; (Тайланг хэвлэмэл болон файл хэлбэрээр 4 хувь бэлтгэн ирүүлэх)

### ОНЦГОЙ НӨХЦӨЛ:

Дараах нөхцөлийг хангасан байна. Үүнд:

1. Төслийн хүрээнд боловсруулагдсан бүх цахим болон хэвлэмэл материал, зураг зэргийг эх хувиар эцсийн тайлангийн хамт Захиалагчид хүлээлгэн өгөх. (Судалгааны явцад эх сурвалжийг тогтмол бүрдүүлэх, анхдагч материалуудыг баримтжуулах)
2. Захиалагч ажлын гүйцэтгэлийг хангалтгүй гэж үзвэл зөвлөмжийн дагуу шаардлагатай өөрчлөлт, боловсруулалтыг хийх.
3. Төслийн хүрээнд цуглуулсан мэдээлэл, үр дүнгийн тайлан, аппликэйшны дизайн зэрэг нь Зохиогчийн эрхийн тухай хуулийн дагуу Хотын стандарт, хяналтын газрын өмч болно.

ХЯНАСАН:  
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА



Э.ДАВААХАТАН

БОЛОВСРУУЛСАН:  
МЭРГЭЖИЛТЭН

О.Нарангуа

О.НАРАНГУА